

**МОНГОЛЫН ӨНДӨР ЗЭРЭГЛЭЛИЙН ШАТАРЧДЫН
ГРАН-ПРИ ТЭМЦЭЭНИЙ
УДИРДАМЖ**

**Орхон
2009.05.15**

аймаг

I. Тэмцээний зорилго

Тэмцээн нь 2010 онд ОХУ-д болох дэлхийн шатрын Олимпод оролцох Монголын олимпийн шигшээ багийн шатарчдыг сонгон шалгаруулах цуврал тэмцээний эхний үе шат бөгөөд шатарчдын ур чадвар, рейтинг чансаа, цол зэргийг ахиулах зорилготой болно.

II. Тэмцээний хугацаа, явагдах газар

Тэмцээн 2009 оны 06-р сарын 17-21-ны өдрүүдэд Орхон аймагт Эрдэнэт үйлдвэрийн “Хангарьд-Палас”-д явагдана.

III. Тэмцээн явагдах журам

1. Тэмцээн “А”, “Б”, “С” гэсэн гурван ангилалаар явагдана.
2. А” ангилалын тэмцээн **2009 оны 06-р сарын 17-21-ний** өдрүүдэд явагдах ба оролцогчдыг 2009 оны 06-р сарын 17-ны өдрийн 09.00 цагаас “Хангарьд-Палас” бүртгэж 10.00 цагаас тэмцээн эхэлнэ.
3. “А” тэмцээнд 2009 оны Улсын аварга шалгаруулах шигшээ тэмцээнд тоглосон 18 шатарчин дээр **2050**-аас дээш дотоод рейтингтэй /2009 оны 1-р сарын байдлаарх/ шатарчид нэмэгдэж оролцох эрхтэй байна.
4. Тэмцээний хураамж 10000 төгрөг байна. /ИМ, ОУМ, ДШХМ цолтой шатарчид хураамжаас чөлөөлөгдөнө./
5. “А” ангилалын тэмцээний цагийн хяналт талдаа 1 цаг 30 минут байна.
6. “Б”, “С” ангилалын тэмцээн **2009 оны 06-р сарын 19-21-ний** өдрүүдэд нээлттэй явагдана. Оролцогчдыг 2009 оны 06-р сарын 19-ны өдрийн 09.00 цагаас “Хангарьд-Палас” бүртгэнэ. Тэмцээний хураамж 10000 төгрөг. “Б” ангилалын тэмцээнд 2050-аас дээш дотоод рейтингтэй шатарчдыг оролцуулахгүй.
7. “С” ангилалын тэмцээн эмэгтэйчүүдийн дунд явагдана. Тэмцээний хураамж 10000 төгрөг байна. /ИМ, ОУМ, ДШХМ цолтой шатарчид хураамжаас чөлөөлөгдөнө./
8. “Б”, “С” ангилалын тэмцээний цагийн хяналт талдаа 1.00 цаг байна.
9. **Тэмцээний нээлтийн ажиллагаа 2009 оны 06-р сарын 20-ны 13.00 цагт**
10. Ангилал тус бүр швейцарь системээр 9 өрөг тоглож дүнгээ гаргана.
11. Оноолтыг компьютерийн программаар хийнэ.
12. Тэмцээний үеэр согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно. Журам зөрчсөн тохиолдолд тамирчныг тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авах эрхийг шүүгч, зохион байгуулагчид эдэлнэ.
13. Тэмцээний үеэр гар утас ашиглахыг хориглоно. Журам зөрчсөн тохиолдолд хожигдсонд тооцно.
14. Тэмцээний дүн мэдээг төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр өргөн сурталчлах ажлыг “ХАНГАРЬД” спорт цогцолбор, МШХ, ОАШХ хариуцна.
15. Тэмцээний рейтингийг тооцно.
16. Ангилал тус бүрийн эхний 3 байр эзэлсэн шатарчинд медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, 4-6-р байр мөнгөн шагналтай. Шагнал давхардахгүй.

Тэмцээнийг зохион байгуулагчид

МОСХ

“ХАНГАРЬД” СПОРТ ЦОГЦОЛБОР

ОАШХ